



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/208

Мөрөн сум

Дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, Засгийн газрын 2021 оны 417 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаал, 2020 оны А/37, А/38 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1а/228 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газрын дүрмийг нэгдүгээр, үлгэрчилсэн бүтцийг хоёрдугаар, орон тоог гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу төсөвтөө багтаан зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч, ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Түвшинбаяр)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

5. Захирамж батлагдсантай холбогдуулан 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/289 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 05
дугаар сарын 02 өдрийн А/203 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

Аймгийн Эрүүл мэндийн газар (цаашид Газар гэх)-ын бүрэн эрх, чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

Газар нь үйл ажиллагаандаа Төрийн хяналт шалгалтын тухай, Эрүүл ахуйн тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, стандартыг мөрдлөг болгоно.

Газар нь иргэдээ дээдэлсэн, тэгш, хүртээмжтэй, чанартай, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах, үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримтална.

Хоёр.Үйл ажиллагааны чиглэл

Газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1.Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлаар:

-Өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар, хөтөлбөр, стратеги, төлөвлөлт хийх, шийдвэр гаргахад аймгийн Засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнана.

-Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, чиглэлээр харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх эрүүл мэндийн үйл ажиллагаанд бусад салбар, иргэдийн оролцоог хангана.

-Хүн амын эрүүл мэндтэй холбогдон гарсан бодлого, хөтөлбөр, тушаал, шийдвэрийг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

-Эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн түвшинд эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

-Үйлчлүүлэгч төвтэй чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээг нэвтрүүлэх талаар онцгойлон анхаарч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тусламж үйлчилгээтэй холбогдон гарсан иргэдийн санал, хүсэлт, гомдлыг барагдуулах, шийдвэрлэнэ.

2.2.Эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар:

-Өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар санал, дүгнэлт гаргах, шийдвэр гаргана.

-Харьяа нутаг дэвсгэрийн хүн амынхаа эрүүл эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, төрийн хүчин чадлаас давсан тусламж үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохицуулах, төлөвлөлт хийнэ.

-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өөрийн орон нутгаас тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага болон төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хувийн хэвшлийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

2.3.Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих чиглэлээр:

-Эрүүл мэндийн байгууллагыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарсан стандарт, тусламж үйлчилгээний багц, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хяналт тавина.

-Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн нөлөөг судлах судалгаа хийх, зөвлөмж гаргана.

-Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах, хуваарилна.

-Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн мэдээ, тайланг нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгнө.

2.4.Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх асуудлаар:

-Эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүн амын эрүүл мэндийн талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлоход шаардлагатай мэдээ, мэдээллээр холбогдох байгууллагуудыг цаг тухайд нь шуурхай хангана.

-Өөрийн харьяа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амын өвчлөл, эндэгдлийн талаарх мэдээг цаг тухайд нь хүлээн авч нэгтгэн, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг эргэн мэдээллээр хангана.

2.5 Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"/цаашид хяналт шалгалт хийх нийтлэг журам гэх/-д заасан хяналт шалгалтын зохицуулах чиглэлээр:

- Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, хуулиар салбарын хяналтын эрх олгосон болон чиг үүрэг шилжүүлж авсан байгууллага, албан тушаалтан /цаашид "салбарын хяналтын байгууллага" гэх/ эрүүл мэндийн салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

-Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар /цаашид Эрүүл мэндийн газар гэх/-ын улсын байцаагч нь зөвхөн төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын төлөвлөлт, хяналтын хуудас, лабораторийн шинжилгээ, авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, албан шаардлага, зөвлөмж, акт, торгууль зэрэг/-ний мэдээллийг хяналт шалгалтын цахим системд тухай бүр бүртгэж мэдээлнэ.

- Хууль тогтоомжид харшлахгүй бол Салбарын хяналтын газар, хяналтын чиглэл хариуцсан улсын ахлах байцаагч /цаашид чиглэлийн ахлах байцаагч гэх/-д танилцуулсан хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлж болно.

- Байгууллагын ил тод байдлыг хангах хүрээнд байгууллагын албан ёсны цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв гаргаж өгнө.

-Эрүүл мэндийн салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үйл явцыг олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллана.

-Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5⁵.1, "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 2.4-т заасны дагуу хяналт шалгалтын объектын эрсдэлийг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан бага, дунд, их гэж ангилна.

-Эрсдэлийн үнэлгээ хийснээс хойш шинээр объект нэмэгдсэн тохиолдол бүрт Салбарын хяналтын газрын Эрсдэлийн удирдлага хариуцсан улсын ахлах байцаагчид мэдэгдэн, тухай бүр эрсдэлийн шалгуураар үнэлгээ хийж, хяналт шалгалтын цахим системд бүртгэнэ.

Гурав. Удирдлага зохион байгуулалт

3.1. Аймгийн Эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж, төрийн албаны тухай хуулийн дагуу аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

3.2. Аймгийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3-д заасны дагуу эрх, үүргээ Эрүүл мэндийн газрын даргад шилжүүлж болно.

3.3. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхээ шилжүүлэн ажилласнаар Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5 заалт, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалтын дагуу Эрүүл мэндийн газрын дарга, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулж, дүгнэнэ.

3.4. Эрүүл мэндийн газар нь удирдлага, санхүү, аж ахуйн хувьд бие даан ажиллах ба "Эрүүл мэндийн газар" гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга хэрэглэнэ.

3.5. Эрүүл мэндийн газар нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү, хөрөнгө, нөөцийг хуваарилах, хяналт тавих асуудлыг хариуцаж аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдад тайлагнана.

3.6. Аймгийн Эрүүл мэндийн газар нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс, Хяналтын шалгалтын хэлтсийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулан ажиллана.

3.7. Эрүүл мэндийн газрын бүтэц үйл ажиллагааны чиглэлийг орон нутгийн хүн ам, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнээс хамааруулан, аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан нарийвчилсан орон тоогоо Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батална.

3.8. Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын дагуу аймгийн Зооноз өвчин судлалын төвийн даргыг аймгийн Засаг даргатай зөвшилцөн Эрүүл мэндийн газрын дарга тушаалаар томилж, чөлөөлнө.

3.9. Эмнэлгийн тусламжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 30 дахь заалтын дагуу Орон нутгийн өмчит Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд Эрүүл мэндийн газраас нэр дэвшигчийн саналыг авч аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

3.10. Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалтын дагуу сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарыг сумын Засаг дарга нь Эрүүл мэндийн газрын даргатай албан бичгээр зөвшилцсний үндсэн дээр тухайн сумын Засаг дарга захирамжаар томилж, чөлөөлнө.

3.11. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Өрх, сумын эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах бөгөөд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн гэрээг байгуулж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, санхүүжилтийг олгож ажиллана.

Дөрөв. Эрүүл мэндийн газрын эрх

4.1. Эрүүл мэндийн газрын эрх

-Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ.

-Харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн бүх эрүүл мэндийн байгууллагуудад хяналт-үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үүрэг, даалгавар өгч биелэлтийг шаардах, хариуцлага тооцно.

-Хүн амын эрүүл мэндийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавина.

-Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийнэ.

-Өөрийн харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, ажилтнуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, урамшуулан дэмжих чиглэлээр төр олон нийт, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төрийн одон медаль, салбарын болон нутгийн захиргааны байгууллагын шагналд нэр дэвшүүлэх, шийдвэрлүүлнэ.

-Өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагын үлгэрчилсэн бүтэц, дүрмийг батална.

-Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээрх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах, тус үйл ажиллагаанд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулна.

-Хуульд заасан эрхийн хүрээнд ажилтныг томилох, чөлөөлөх, албан тушаалаас нь бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр чөлөөлөх, хална.

-Эрүүл мэндийн чиглэлээр эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг зохион байгуулна.

-Эрүүл мэндийн байгууллагад гарсан шинэ бүтээл, дэвшилтэт технологид дүгнэлт гаргах, санал өгнө.

-Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийн байдалд хяналт тавих, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авна.

4.2. Эрүүл мэндийн газрын үүрэг

-Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн акт, стандарт, удирдамж, тусламж үйлчилгээний багц, Улсын байцаагчийн акт, шаардлагыг хэрэгжүүлнэ.

-Засаг даргаар ахлуулсан “Эрүүл мэндийн зөвлөл”-ийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж, хурал зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн бэлтгэнэ.

-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран гүйцэтгэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, тэргүүлэх чиглэлээ тогтоож түншлэлийн чиглэл, хэтийн төлөвийг тодорхойлно.

-Ядуу, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

-Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний талаарх иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тодорхой давтамжтайгаар авч мэдээлэх, судалгааны мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

-Албан бус төлбөрийг бууруулах, төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тарифыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах арга хэмжээг зохион байгуулж хяналт тавина.

-Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөллийн үнэлгээ болон эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагатай хамтран хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох дээд шатны байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

-Хүн амын өвчлөлийн чиг хандлага, эмнэлгийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулж өөрийн орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийх, харьяа эрүүл мэндийн байгууллагын хөрөнгийн бүртгэлийн мэдээний санг байгуулах, тогтмол шинэчилнэ.

-Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулна.

-Эм хангамжийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авна.

-Харьяа эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, гүйцэтгэлийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

-Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хүний нөөцийн төлөвлөлт хийнэ.

-Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хүний нөөцөөр хангах үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулна.

-Өөрийн орон нутагт явуулж эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчинг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах нөхцөлөөр хангана.

-Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээг зохион байгуулна.

-Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа доголдлыг бүртгэн мэдээлнэ.

-Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах хянах, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага байна.

-Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, стратегийг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтийг зохион байгуулна.

-Зонхилон тохиолдох өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үнэлгээ хийх, хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагааг дангаараа болон бусад эмнэлэг мэргэжлийн төвүүд, салбар аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт иргэдтэй хамтран аймгийн түвшинд зохион байгуулна.

-Хүн амын дундах өвчлөлийг тандах, эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж эмчлэн эдгэрүүлэх үйл ажиллагааг харьяа орон нутгийн эмнэлгийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

-Хүн амын дунд биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр чийрэгжих, эрүүл зөв хоололтыг дэмжих, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр чийрэгжүүлэлтийн, хоол зүй, сэтгэл зүй, донтолт, хүчирхийллийн эсрэг зөвөлгөө өгөх болон өсвөр үе ахмадын эрүүл мэндийн нэгжийг байгуулан ажиллаж болно.


-Халдварт болон халдварт бус өвчин болон хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийн талаар тандалт судалгаа хийж, мэдээний сан байгуулан ажиллана.

_____оОо_____



Аймгийн Засаг даргын 2023 оны 05
дугаар сарын 02 өдрийн 1/2028 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЛГЭРЧИЛСЭН БҮТЭЦ



Аймгийн Засаг даргын 2023 оны 05
дугаар сарын 02 өдрийн А/208 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Дарга	1	ТЗ

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Хэлтсийн дарга	1	ТЗ
2	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн /Ахлах мэргэжилтэн/	1	ТЗ
3	Эрүүл мэндийн салбарын ёс зүйн, нийгмийн асуудал, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
4	Хууль, эрх зүйн зөвлөгөө хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
5	Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт хариуцсан нягтлан бодогч	1	ТҮ
6	Санхүүгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, дотоод аудит хариуцсан нягтлан бодогч	1	ТҮ
7	Эмнэлгийн тоног төхөөрөмж, барилгын чанар, аюулгүй байдал, засвар үйлчилгээ хариуцсан инженер	1	ТҮ
6	Ахлах нягтлан бодогч	1	ТҮ
5	Бичгийн хэргийн ажилтан	1	ТҮ
6	Архив, гадаад харилцаа хариуцсан ажилтан	1	ТҮ
7	Нярав	1	ТҮ
8	Жолооч	3	ТҮ
9	Жижүүр	2	ТҮ
10	Сантехникч, цахилгаанчин, жижүүр	1	ТҮ
Дүн		18	

2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Хэлтсийн дарга	1	T3
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	1	T3
3	Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах (ахмад, хөгжлийн бэрхшээл), тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3
4	Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3
5	Хүүхэд, яаралтай тусламж хариуцсан мэргэжилтэн (Ахлах мэргэжилтэн)	1	T3
6	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн	1	T3
7	Сувилахуй, хөнгөвчлөх, тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3
8	Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3
9	Төр, хувийн хэвшлийн түншлэл, эмнэлгийн тусгай зөвшөөрөл, гамшиг хариуцсан мэргэжилтэн	1	T3
Дүн		9	

3. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Төвийн дарга	1	T3
2	Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн /Ахлах мэргэжилтэн/	1	T3
3	Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1	T3
4	Тархвар судлал хариуцсан мэргэжилтэн	1	T3
5	Хоол тэжээл хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1	T3

6	Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, осол гэмтлийн хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
7	Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
8	Орчны эрүүл мэнд, ХАБ, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
9	Өсвөр үеийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
10	Дархлаажуулалт хариуцсан бага эмч	1	ТҮЭМ
Дүн		10	

4. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Хэлтсийн дарга	1	ТЗ
2	Эрүүл мэндийн статистик ,мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн /Ахлах мэргэжилтэн/	1	ТЗ
3	Санхүүгийн дотоод аудит хариуцсан нягтлан	1	ТҮ
4	Мэдээллийн технологи, зайн оношилгоо хариуцсан инженер	1	ТҮ
5	Мэдээллийн технологи, засвар үйлчилгээ, сүлжээ хариуцсан инженер	1	ТҮ
6	Эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл хариуцсан бага эмч	2	ТҮЭМ
Дүн		7	

5. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Хэлтсийн дарга	1	ТЗ
2	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (Орчны эрүүл ахуйн асуудал хариуцсан)	1	ТЗ
3	Эмчилгээний чанарын улсын байцаагч	1	ТЗ
4	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (Халдвар судлалын хяналтын асуудал хариуцсан)	1	ТЗ

5	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (Хүүхэд, өсвөр үе хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын асуудал хариуцсан)	1	T3
Дүн		5	
Нийт		49	

_____oOo_____